



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/190

Ховд

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, цуцлах, түтгэлзүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1, 19.3.2, 19.17.1, 19.17.2, 19.20.1, 19.20.2, 19.20.5 дахь заалтууд, аймгийн Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь дуусч үргэлжлүүлэн ажиллах нөхцөл шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон Үенч, Мянгад, Чандмань, Зэрэг, Цэцэг, Манхан сумын Эрүүл мэндийн төвүүдийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, Чандмань, Дуут сумын эргэлтийн эмийн сан, Жаргалант сумын “Алтан агь энх” хувийн эмийн сангуудын эмийн худалдаа үйлчилгээ үзүүлэх, Мөнгөн морьт хувийн ортой эмнэлгийн дотор, эмэгтэйчүүд, мэдрэлийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг тус тус 5 жилээр сунгасугай.

2. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад хүний нөөц дутагдалтай, орон байрны нөхцөл шаардлага хангахгүй, зайлшгүй шаардлагатай эмийн нөөц 27 хувьтай, хяналт үнэлгээгээр үйл ажиллагаа 46 хувьтай дүгнэгдсэн “Хөөр бал Алтай” эмийн сан, тусгай зөвшөөрлөө аваад үйл ажиллагаагаа эхлүүлэлгүй 2 жил болсон “Булган алтан гадас” эмийн сангийн үйл ажиллагааг тус тус цуцалж, ажиллах хүний нөөц дутуу, орон байрны шаардлага нь стандартад нийцэхгүй байгаа “Түмний ачит тунгалаг” эмийн сангийн эм худалдаалах, борлуулах үйл ажиллагааг 3 сарын хугацаатай түр түтгэлзүүлсүгэй.

3. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах мэргэжлийн эмчгүй тул “Ара дент”, “Сувдан шигтгээ” шүдний эмнэлгүүдийн согог засал, хиймэл шүдний тусламж

үйлчилгээг хасахаар, Үенч сумын эргэлтийн эмийн сангийн эрхлэгч өвчний учир нас барсан тул эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагааг “Аюургиваа” ХХК-ний нэр дээр шилжүүлэхээр тус тус мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсугай.

4. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан, түтгэлзүүлсэн, нэмэлт өөрчлөлт оруулсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Мягмарсүрэн/, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга /Д.Оюунцэцэг/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ